

**“ХӨХ ГАН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2024 оны 04 сарын 29 өдөр

Улаанбаатар хот

“Хөх Ган” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04 сарын 29-ний өдрийн 14:00 цагт “Нэхээсгүй эдлэл” ХК-ний 3 давхарт хурлын танхимд эхлэв.

Хурлын дэгийн дагуу 14:10 хүртэл ирц бүртгэсэн.

Хурлын дарга Л.Бямбадорж Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэгийг танилцуулав. Үүний дараагаар Тооллогын комисс хурлын ирцийн тогтоолыг танилцуулав. Компанийн ээлжит хуралд нийт саналын эрхтэй хувьцааны 85.89% буюу 87 018 978 ширхэг хувьцаа эзэмшиж буй 2 хувьцаа эзэмшигч оролцож ирц хүрсэн.

Хурлын дарга Хөх Ган ХК-ний гүйцэтгэх захирал Л.Бямбадорж хэлэлцэх асуудлуудыг танилцуулсан.

Хэлэлцсэн:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж батлах
2. Компанийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг томилох
4. ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн даргын цалин, ТУЗ-ийн зардлын төсөв батлах тухай
5. ТУЗ-аас гаргасан Ногдол ашиг тараахгүй тухай шийдвэрийг танилцуулах

Танилцуулсан:

Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцсэний дараагаар 2024 оны компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцууллаа.

2024 ОНЫ ХИЙГДЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

	Ажлын төрөл	Огноо	Төсөв, сая төг
I	Кокс, магнет нунтаг үйлдвэрлэлийн зардал	III-IV улирал	2026.3
II	Барилга байгууламжын засвар, арчлалт	III-IV улирал	32.4
III	Судалгаа туршилтын ажлуудын чиглэл	III-IV улирал	24.4
IV	Хабза, байгаль орчны ажиллагаатай холбоотой асуудлууд	II-IV улирал	18.4
	Нийт		2,101.5

I. Кокс, нунтаг магнет үйлдвэрлэлийн бэлтгэл ажил, Механикжуулалт

	Ажлын нэр	он	Хариуцагч	Ач холбогдол
1	Хийжүүлэх зууханд нүүрс ялгах, тэжээх дамжлагыг механикжуулах	2024	Ерөнхий механик	1. Ажлын нөхцлийг сайжруулах 2. Орон тоог 3 хүнээр цөөрүүлнэ.
2	Коксжуулах нүүрсийг савлах, хольц бэлтгэх ажиллагааг механикжуулах техникийн шийдэл гаргаж, зардлыг тодорхойлох	2024	Ерөнхий механик	1. Нүүрс бэлтгэх технологийн шийдэлтэй уялдуулах
4	Кокс буулгах ачих ажиллагаанд урсгуур тавцан, бункер, конвейер суурилуулах.	2024-2025	Ерөнхий механик	1. Хуримтлуулах бункерын багтаамж нь зөөх автомашины тэвшны багтаамжаас багагүй байх 2. Байрлалыг сонгохдоо ШАТ, агломерат буулгах хадгалах ажиллагааг тооцох
5	Кокс унтраах хөргөлтийн усны эргэлтийн сан байрлуулах, ус цуглуулах шуудуунд эргэлтийн насос угсрах	2024-2025	Ерөнхий цахилгаанчин	1. Нөөц сангийн дүүргэлтийг автоматажуулж, тоолуур тавьснаар зарцуулалтыг хянах
6	Форсунк цэвэрлэх хоолойн тагийн хийцийг өөрчлөх	2021	Ерөнхий механик	1. Цаг зарцуулалтыг багасгах

II. БАРИЛГА БАЙГУУЛАМЖЫН ЗАСВАР, АРЧЛАЛТ

	Ажлын нэр	он	Хариуцагч	Ач холбогдол
1	Дээврийн хэсэгт налуу үүсгэж, хэсэгчилсэн завсарт оруулж, даацын двутаврын зэврэлийг цэвэрлэж, будах	2021-2022	үйлдвэрийн дарга	Барилгын насжилт сайжрана.
2	Агааржуулалтын асуудлыг, дээврийн засвартай цогцоор шийдэх	2021-2022	Ерөнхий цахилгаанчин	Үйлдвэрлэлийн ХАБЭА-н орчин сайжрина.
3	Хөргөх цэг дээр уур цуглуулах, татах вентилятор суурилуулах	2021-2022	Ерөнхий цахилгаанчин	Барилгын хийцийг хамгаалах

4	Коксжуулах нүүрс бэлтгэх байгууламжийг барилгажуулах	2021- 2022	үйлдвэрийн дарга	1. Бүхэллэг нүүрс ашиглах туршилтын үр дүнгээс хамаарна. 2. Туузан конвейр дамжлага нэмэх
---	--	---------------	------------------	---

III. СУДАЛГАА ТУРШИЛТЫН АЖЛУУДЫН ЧИГЛЭЛ

	Ажлын нэр	он	Хариуцагч	Ач холбогдол
1	Үйлдвэрлэлийг барилгын материал үйлдвэрлэл руу шилжүүлэх		Гүйцэтгэх захирал	Үйлдвэрлэлийн ашиг ажиллагааг нэмэгдүүлэх
2	Бортого, галд тэсвэртэй тоосго хавтангуудын хаягдлыг дахин ашиглаж тэргэнцэрийн хамгаалалтын блок үйлдвэрлэх	2 0 2	Ерөнхий технологи	Экспортоор нийлүүлэх тэргэнцэрийн хамгаалах тоосгыг орлуулна.
3	Бортогын шинэ хийц, материалыг тодорхойлох туршилтуудыг хийх.	2 0	Ерөнхий технологи	1. Туршилт эхэлсэн.үр дүн сайн үзүүлэлтэй бна.
	Нүүрсний коксжуулах чиглэлээр технологийн туршилт хийж, үйлдвэрлэлд нэвтрүүлэх	2 0 2	Ерөнхий технологи	
	Төмрийн баяжмалаас хорголж үйлдвэрлэх судалгаа, туршилт хийх	- 2	Ерөнхий технологи	

ХАБЭА, БАЙГАЛЬ ОРЧИНЫ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ АСУУДЛУУД-1

	Ажлын нэр	он	Хариуцагч	Ач холбогдол
1	Галын цэгүүдийн байршлыг дахин хэлэлцэж, шаардлагын дагуу тоноглох	2024	ХАБ хариуцсан мэргэжилтэн	1. Мэргэжлийн байгууллагаас санал, дүгнэлт гаргуулах
2	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянуулах	2024		
2	Улсын хяналтын байгууллагууд болон байгууллагын хяналтанд байх өргөх төхөөрөмж, даралтат сав, тоноглолын хяналт болон бүрэн бүтэн байдлыг хариуцсан ажилтнуудыг	2024	Үйлдвэрийн дарга Ерөнхий механик Ерөнхий цахилгаанчин	

	тушаалаар томилж, зохих сургалтанд хамруулан тусгай зөвшөөрөл үнэмлэхтэй болгох			
3	Өргөх механизм, ган татлага, тоноглол, даралтат хоолойг бүртгэн паспортжуулж, журманд заасан үечлэлийн дагуу үзлэг шалгалтыг гүйцэтгэх	2024	Ерөнхий механик Ерөнхий цахилгаанчин	
4	1.2-р хийжүүлэх зүүхны уурын даралтат ресиверийн техникийн магадлагааг гүйцэтгэж ашиглах зөвшөөрлийг авах	2024	Ерөнхий цахилгаанчин	
5	Цахилгаан тоног төхөөрөмжтэй харьцах ажилтнуудад сургалт явуулж, зэрэглэлийн үнэмлэх олгох	2024-2025	Ерөнхий цахилгаанчин	Аюулгүй ажиллагаа сайжрана.
6	Үйлдвэрийн эрчим хүчний чадлын нэмэгдүүлэх, ЭХЯамнаас 2 МВт техникийн нөхцөл авах	2024-2025	Ерөнхий цахилгаанчин	Эрчим хүчний хуулийн дагуу үйлчилгээ хийх
7	Барилга байгууламжууд, машин тоног төхөөрөмжүүдийг газардуулгын туршилтанд оруулах	2024-2025	Ерөнхий цахилгаанчин	Гэмтэл саатлаас сэргийлнэ.
8	Үйлдвэрийн хог хаягдалын гэрээг холбогдох байгууллагатай хийх	2024-2025	Үйлдвэрийн дарга Ерөнхий механик	БОМТөлөвлөгөөний дагуу

Дараагийн хэлэлцэх асуудал :ТУЗ-д нэр дэвшигчдийг танилцуулсан.

“Хөх Ган” ХК- Ердийн болон Хараат бус ТУЗ-ийн гишүүд:

Ердийн гишүүдэд:

1. Б.Мөнхтөр
2. М.Цэлмэг
3. Д.Даянбилгүүн
4. Б.Лхагвадорж
5. П.Золжаргал
6. С.Батзориг

Хараат бус гишүүдэд:

1. Б.Алтансүвд
2. Д.Энхжин
3. С.Дуламсанж

ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулсны дараа ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн даргын цалин, ТУЗ-н зардлын төсвийг батлах тухай хэлэлцэж, компанийн үйлдвэрийн үйл ажиллагаа явагдаж эхэлсний дараа асуудлыг хэлэлцэхээр тогтов.

Хамгийн сүүлд хурлын дарга ТУЗ-өөс гаргасан ногдол ашиг тараахгүй тухай шийдвэрийг танилцууллаа.

Үүний дараа санал хурааж тооллогын комиссын дүнг танилцуулав.

-Хурлын ирц 85,89%

-Хувьцаа эзэмшигчдийн нийт 85,89%-ын санал өгсөнөөс нийт 2 саналын хуудас ирсэн. Үүнээс хүчинтэй саналын хуудас 2. Хүчингүй саналын хуудас байхгүй.

Хурлаар дараах асуудлуудыг ердийн аргаар санал хураан шийдвэрлэв.

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг батлах:

Зөвшөөрсөн – 87 018 978 ширхэг хувьцаа буюу 85.89%

Татгалзсан - .. ширхэг хувьцаа буюу ..%

Түдгэлзсэн - .. ширхэг хувьцаа буюу ..%

2. Компанийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах:

Зөвшөөрсөн – 87 018 978 ширхэг хувьцаа буюу 85.89%

Татгалзсан - .. ширхэг хувьцаа буюу ..%

Түдгэлзсэн - .. ширхэг хувьцаа буюу ..%

3. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг батлах:

Зөвшөөрсөн – 87 018 978 ширхэг хувьцаа буюу 85.89%

Татгалзсан - .. ширхэг хувьцаа буюу ..%

Түдгэлзсэн - .. ширхэг хувьцаа буюу ..%

4.

Зөвшөөрсөн – 87 018 978 ширхэг хувьцаа буюу 85.89%

Татгалзсан - .. ширхэг хувьцаа буюу ..%

Түдгэлзсэн - .. ширхэг хувьцаа буюу ..%

Хурлаар дараах асуудлыг кумулятив аргаар санал хураан шийдвэрлэв.

5. Саналын хуудсаар “Хөх Ган” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай асуудлаар хуралд оролцсон саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн өгсөн саналын дүн:

Ердийн гишүүдэд өгсөн санал:

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Б.Мөнхтөр	100	87 018 978
2	М.Цэлмэг	100	87 018 978
3	С.Батзориг	100	87 018 978
4	Д.Даянбилгүүн	100	87 018 978
5	Б.Лхагвадорж	100	87 018 978
6	П.Золжаргал	100	87 018 978

Хараат бус гишүүдэд өгсөн санал:

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Д.Энхжин	100	87 018 978
2	С.Дуламсанж	100	87 018 978
3	Б.Алтансүвд	100	87 018 978

тус тус санал авч эдгээр гишүүд ТУЗ-ийн гишүүдэд сонгогдов.

Хурлын дарга хурлын хааж үг хэлснээр хурал 14 цаг 30 минутад дуусав.

Тэмдэглэл хөтөлсөн:  / Т.Болор-Отгон /

Тэмдэглэл хянасан:  / Л.Бямбадорж /